

Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC

UNFPA
НҮБ-ын Хүн Амын Сан

# ГИНЖИЙГ ТАСАЛ!

Жендэрт суурилсан хүчирхийллийн үр дагаврыг залуучуудад таниулах, урьдчилан сэргийлэх мэдлэг олгох зорилготой зурагт ном.

“Хөөрхөн Зүрх” ТББ–аас санаачлан НҮБ–ын Хүн амын сан, Швейцарийн хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр жендэрт суурилсан хүчирхийллийг таслан зогсооход олон нийтийг уриалан дуудах “Гинжийг тасал – 2” нөлөөллийн кампанит ажлын хүрээнд энэхүү зурагт номыг гаргав. Нийтлэг тохиолддог хүчирхийллийн дөрвөн төрөл буюу бие махбод, сэтгэл санаа, эдийн засаг, бэлгийн хүчирхийллийн талаарх ойлголтыг нэмэгдүүлж, үүнээс сэргийлэх, мэдлэг мэдээлэл өгөх зорилготой.

Энэхүү зурагт номыг үнэ төлбөргүй олон нийтэд тараах бөгөөд худалдан борлуулахыг хориглоно. Мөн “Хөөрхөн Зүрх” ТББ–ын зөвшөөрөлгүйгээр хувилан олшруулахыг хориглох бөгөөд бүтнээр нь болон хэсэгчлэн ашиглах тохиолдолд эх сурвалжийг заавал дурдана.

Зохиолыг бичсэн:
Ц.Очгэрэл, сэтгүүлч, хүний эрхийн хамгаалагч
Ц.Ононтуул, нийгмийн ажилтан, хүний эрхийн хамгаалагч
Ц.Баасаннямбуу, нийгмийн ажилтан, хүний эрхийн хамгаалагч

Хянан тохиолдуулсан:
А.Хонгорзул, сэтгэл зүйч
Б.Оюундарь, клиник нийгмийн ажилтан
П.Энхчимэг, сэтгэл зүйч

Зураач: Г.Саранчимэг

2018 он

/btifulhearts

70159688


СОНГОЛТ
МИНИЙ ГАРТ


ЭНХЛЭН, АНАР ХОЁР 18 НАСТАЙ. ТЭД ИХ СУРГУУЛИЙН ШИНЭХЭН ОЮУТНУУД.
ТЭД ҮЕРХЭЭД ЖИЛ ГАРУЙ БОЛЖ БУЙ БИЕ БИЕДЭЭ ХАМГААС ХАЙРТАЙ ХОСУУД.


ЭНХЛЭН ХӨДӨӨНӨӨС ИРЖ СУРАЛЦДАГ. ТЭР ХОТОД НЭГ ӨРӨӨ БАЙР ТҮРЭЭСЛЭН АМЬДРАЛАА ӨӨРӨӨ ЗОХИЦУУЛДАГ.
АНАРЫНХ ХОТЫН АЙЛ БӨГӨӨД ТЭРЭЭР ХОЁР ЭГЧТЭЙ, АЙЛЫН ГАНЦ ХҮҮ.


ХАЙРДАА, ХОЁУЛАА ИНГЭЭД ХАМТ АМЬДАРДАГ БОЛ ЯМАР ВЭ?
ЁСТОЙ ГОЁ ДОО! ЧИ МАНАЙД НҮҮГЭЭД ИРЭЭЧ?
ТЭГЬЕ, НЭГЭНТ ХОЁУЛАА ГЭР БҮЛ БОЛНО ГЭЖ БАЙГАА ЮМ ЧИНЬ...
ТАНАЙД ХАМТ АМЬДАРЯ!
ТУСДАА ГАРААД, ЁСТОЙ ГОЁ БАЙНА БАЙХ ДАА?
ХАЙРТАЙ ШҮҮ!
ИЙНХҮҮ ЭНХЛЭН АНАР ХОЁР НЭГ НЭГНИЙГЭЭ ИЛҮҮ САЙН МЭДЭЖ ОЙР ДОТНО БОЛОХЫН ТУЛД ЭНХЛЭНГИЙН ТҮРЭЭСЛЭДЭГ БАЙРАНД ХАМТ АМЬДРАХААР БОЛЛОО...


ЗАХИАЛГА БЭЛЭН!
KFS
KFS
ТЭД ХАМТ АМЬДАРДАГ БОЛСОНООС ХОЙШ ЭНХЛЭН ГЭРИЙН АЖЛАА БҮГДИЙГ НЬ ХИЙЖ БАЙЛАА. УЧИР НЬ ЭР ХҮН ГЭРИЙН АЖИЛД ОРОЛЦОХ ЁСГҮЙ ГЭЖ ГЭРИЙНХЭН НЬ ТҮҮНИЙГ ХҮМҮҮЖҮҮЛЖЭЭ.


ТЭГЬЕ, ЯВЖ ТОГЛОЕ!
СҮҮЛИЙН ПААР-ДА ТАСЛАХ УУ?
ХАРИН АНАР БОЛ ХИЧЭЭЛДЭЭ АЛДАГ ОНОГ ЯВАХААС ӨӨР АЖИЛГҮЙ ГАДУУР ТЭНЭЖ, PC ТОГЛООМ ТОГЛОНО. АЙЛЫН ЭРХ ХҮҮ ТЭРЭЭР БҮХИЙ Л ЗҮЙЛСЭЭ ЭЭЖ, ЭГЧ НАРААРАА ХИЙЛГЭЖ ӨСЧЭЭ.
БУУДАААД! ХУРДЛААЧ ДЭЭ!


ХАЙРАА, БИ ИРЛЭЭ!
ИНГЭЭД!
ТА-ТА-ТА
ҮХЭЭД ӨГ!
ӨӨ
CHIPS
ЯМАР ЗАМБАРААГҮЙ БОЛЧИХОО ВЭ?
БИД ХОЁР ХАМТДАА Л АЗ ЖАРГАЛТАЙ...
ТИЙМ Ч УЧРААС ЭНЭ ЗЭРГИЙН ЗҮЙЛ ЮУ Ч БИШ.


ХАВАР БОЛЖ ШАЛГАЛТУУД ЭХЛЭЖ, ХИЧЭЭЛ, ЦАГИЙН АЖИЛДАА ЯДАРСАН ЭНХЛЭНГ ГЭРТЭЭ ИРЭХЭД ЭЦЭС ТӨГСГӨЛГҮЙ ГЭРИЙН АЖИЛ УГТАНА.
ХАЙРАА, ХООЛ ХИЙГЭЭРЭЙ.
ӨЛСӨЖ ҮХЭХ НЬ
АНАР НАМАЙГ ХААЯА Ч БОЛОВ ОЙЛГООД
ТУСЛАДАГ БОЛ ...
ЯДАРЧ БАЙНА ШҮҮ.


ГЭТЭЛ НЭГЭН АМРАЛТЫН ӨДӨР...
БИ ГЭРЭЭ ЦЭВЭРЛЭЭД, ХУВЦАСАА УГААЧИХЛАА. ОДОО ХООЛ ХИЙНЭ ЭЭ, ТЭГЭЭД ШАЛГАЛТАНДАА БЭЛДЭНЭ ЭЭ.
МИНИЙ ХАЙР ГАРААД ХОГ ХАЯЧИХААРАЙ.
ЮУ? ХОГ ХАЯХ АА? ХЭЗЭЭ ЭРЭГТЭЙ ХҮН ХОГ ХАЯЖ БАЙЛАА ДАА?
ЧИ ОДОО МЭДЭХГҮЙ Л БАЙВ ГЭЖ ДЭЭ.
АРАЙ ДАВАРЧ БАЙГАА ЮМ БИШ ҮҮ?
...
НЭЭРЭЭ Ч... ХЭЗЭЭ ЭРЭГТЭЙ ХҮН ХОГ ХАЯЖ БАЙЛАА ДАА. ШАЛ ДЭМИЙ ЗҮЙЛ ЯРИЛАА
. . .


ЭНХЛЭНГ ДУУГҮЙ ХҮЛЦЭНГҮЙ БАЙХ БҮРТ АНДАР УЛАМ ДАВАРЧ, ЭНХЛЭНГ БАЙНГА Л ГЭРИЙН АЖЛААР ЧИЧИЛДЭГ БОЛОВ.
19:07
ЭМЭГТЭЙ ХҮН БАЙЖ ЭНЭ ГЭР ОРНОО ХАРДАА! АРЧААГҮЙ ЮМ!
ӨМСЧИХ ЦЭВЭРХЭН ОЙМС Ч БАЙХГҮЙ!
НЭГ Л ИХ ЗАВГҮЙ! ХААГУУР ЯВААД БАЙДАГ ЮМ? НАМАЙГ ХАР, БҮҮР НҮДНЭЭС ГАРЧИХСАН БАЙГАА БИЗ?
Б-БИ ХИЧЭЭНЭ ЭЭ.
ХАЙР НЬ ГЯЛС ХООЛ ХИЙГЭЭД ӨГЬЕ.


ЭНХЛЭН ХАЙРТАЙ ХҮНИЙХЭЭ ТӨЛӨӨ "ХИЧЭЭХЭД Л БОЛНО" ГЭЖ ӨӨРИЙГӨӨ ЯТГАН, АЛЬ БОЛОХ БҮХНИЙГ АМЖУУЛАХ ГЭЖ ХИЧЭЭНЭ. НЭГ МЭДЭХЭД ТЭР НАЙЗУУДААСАА Ч ХӨНДИЙРЧ, ҮРГЭЛЖ ГЭР ЛҮҮГЭЭ ЯАРСААР Л ...
ДАН
БИ АМЖИХГҮЙ ЭЭ.
ГАРЧ ЮМ ИДЭХ ҮҮ?
ЭНХЛЭН ТАРААД Л ЗУГТЧИХ ЮМАА ...
ХАРИН ТИЙМ ...
ЕРӨӨСӨӨ ҮЗЭГДЭХЭЭ БАЙЛАА.
ХУРДАН ХАРЬЦАД АНАРТ ХООЛ ХИЙГЭЭД, ГЭРЭЭ ЦЭВЭРЛЭЭД, ХУВЦАСАА УГААХГҮЙ БОЛ... АНАР УУРЛАНА ДАА . . .


ГЭТЭЛ НЭГ ӨДӨР ЭНХЛЭН ГЭРТЭЭ ХАРИХ ЗАМДАА АВТОБУСАНД РАДИОГООР ИЙН ЯРЬЖ БАЙХЫГ СОНСОВ:
ТИЙМ ШҮҮ. ГЭРИЙН АЖИЛ ГЭДЭГ ГАНЦААРДАА ХИЙХ АЖИЛ ЕРӨӨСӨӨ БИШ. ЭМЭГТЭЙ ХҮН ЭНЭ АЧААГ
ГАНЦААРДАА ҮҮРЭХ ЁСГҮЙ. ГЭР БҮЛИЙН БҮХ ГИШҮҮД БИЕ БИЕНЭЭ ОЙЛГОН,
ИЖИЛ ТЭГШ ХУВААЖ ХИЙХ ЁСТОЙ.
САНАЛ НЭГДЭЖ БАЙНА. ГЭХДЭЭ МАНАЙД ЭЭЖ Л БҮГДИЙГ ХИЙДЭГ БАЙСАН.
ГЭРИЙН АЖЛЫГ БҮГД Л ХУВААЖ ХИЙХ ЁСТОЙ. ОДОО БОДОХОД МАШ ИХ ЯДАРДАГ БАЙЖЭЭ.
МАНАЙД Ч БАС. ИЙМ БУРУУ ХАНДЛАГА БАЙСАН.
ХҮҮХДИЙГ БАГААС НЬ ИНГЭЖ ХҮМҮҮЖҮҮЛЭХЭЭР ОХИДООД ИЙМ Л БАЙХ ЁСТОЙ МЭТ САНАГДДАГ. ГЭТЭЛ АМЬДРАЛ ИЙМ БИШ.
МИНИЙ ХАНЬ МУНДАГ ШҮҮ. НАДАД ҮРГЭЛЖ ТУСЛАДАГ.
БАЯРЛАЛАА.
ТИЙМ ШҮҮ, ЁСТОЙ ҮНЭН ЯРЬЖ БАЙНА.
ГЭРИЙН БИШ ГЭР БҮЛИЙН АЖИЛ ШҮҮ ДЭЭ.



Гэрийн ажил: Яагаад зөвхөн
хийх ёстой гэж?
ЖЕНДЕРИЙН ТЭГШ БАЙДЛЫН
ФЕМИНИЗМ ГЭЖ ЮУ ВЭ?
ГЭРИЙН ХОГИЙГ ХЭН ГАРГАХ ЁСТОЙ ВЭ?
НЭГЭН ЭМЭГТЭЙН ӨӨРИЙГӨӨ
ГЭР БҮЛИЙН ЭРҮҮЛ
ЗӨВ ХУВААРИЛАЛТ


ХАЙРАА ...
ХОЁУЛАА ГЭРИЙН АЖЛАА ХУВААЖ ХИЙВЭЛ ЯМАР ВЭ?
ЮУ ?
БИ ТЭГЭЭД ОДОО ГЭРИЙН АЖИЛ ХИЙХ ҮҮ ТЭ?
ЧИ ТЭГЭЭД НАДААР ГЭР ОРНОО ЦЭВЭРЛҮҮЛЭХ ГЭЭ ЮУ? МАНАЙД ЭЭЖ ЭГЧ НАР Л ХИЙДЭГ. ЧИ ХУДЛАА ЗАЛХУУРААД ИНГЭЭ БИЗ. ЭМЭГТЭЙ ХҮН ГЭРИЙН ХАМАГ АЖЛАА ХИЙДЭГ БАЙХ ЁСТОЙ.
ЧИ ЕР НЬ СУРЧ ЯАХ ГЭСЭН ЮМ?
ГЭРТЭЭ Л БАЙЖ БАЙХАД БОЛОХ ЮМ БИШ ҮҮ? ЭМЭГТЭЙ ХҮН ЧИНЬ ЦЭВЭР ЦЭМЦГЭР БАЙХ ЁСТОЙ ШҮҮ.
ЧИ АРАЙ ХЭТЭРЧ БАЙНАДА. ХҮМҮҮС ЮУ ГЭЖ ХЭЛЭХ ВЭ?
ЧИ БОДООО. БИ ЛАВ ЧАМААС ИЧИЖ БАЙНА АА.


БИ ЧАМД ХАЙРТАЙ Л ДАА, ГЭХДЭЭ ЯАГААД БИ ЭМЭГТЭЙ ГЭЭД БҮХ ЮМАА ГАНЦААРАА ХИЙХ ЁСТОЙ ГЭЖ?
БИД ХОЁР ХАМТ АМЬДАРЧ БАЙГАА ЮМ ЧИНЬ, ХАМТДАА Л ХИЙХ ЁСТОЙ.
БИЕ БИЕНЭЭ ДЭМЖЭЭД, ЖАРГАЛТАЙ БАЙХ ЁСТОЙ БИЗ ДЭЭ?
ЧИ ЭНИЙГ УНШДАА, ЭНЭ НИЙТЛЭЛ ГЭР БҮЛИЙН ҮҮРГИЙН ТУХАЙ.
?
ТЭГЭЭД БИ ГЭРИЙН АЖИЛ ХИЙХ ЁСТОЙ ГЭЖ ҮҮ? ХММ....
БИ ОЙЛГОЖ БАЙНА Л ДАА, ГЭХДЭЭ ....
ЯГ ҮНЭНИЙГ ХЭЛЭХЭД, БИ БАГААСАА ГЭРИЙН АЖИЛ ХИЙЖ ҮЗЭЭГҮЙ ЭЭ, ОДОО Ч ХИЙХ БОДОЛГҮЙ БАЙНА.
ММ... ЧИНИЙ БОДОЛ ЭНЭ ҮҮ?
НАДАД ХАМТ АМЬДАРЧ БАЙГАА Ч ГЭР ОРНЫ АЖЛЫГ ГАНЦААРАА ХИЙЖ ЦАГ ХҮЧ ЗАРЦУУЛЖ БАЙГАА НЬ ХЭЦҮҮ БАЙНА АА


БИ ЭНЭ АЧААГ ГАНЦААРАА ҮҮРМЭЭРГҮЙ БАЙНА АА, АНАРАА.
ТЭГЭХЭЭР... ЧИ БИД ХОЁР ИНГЭЭД ХАМТ АМЬДРАХГҮЙ ГЭСЭН ҮГ ҮҮ?
ИЙНХҮҮ ЭНХЛЭН АНАР ХОЁР УДААН ЯРИЛЦСАНЫ ЭЦЭСТ ҮЕРХЛИЙН ХАРИЛЦААГАА ХЭВИЙН ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ Ч ХАМТДАА АМЬДРАХАА БОЛИХООР ШИЙДЭВ. ЭНЭ НЬ ТЭР ХОЁРЫН ХҮСЭЛ СОНИРХОЛД НИЙЦСЭН, ХЭН ХЭН НЬ СЭТГЭЛ ХАНГАЛУУН ҮЛДЭХ ШИЙДВЭР БАЙЛАА.
АНАР ЦААШИД ЭНЭ ТУХАЙ НАЙЗУУДТАЙГАА ЯРИЛЦАН ИЛҮҮ ИХ МЭДЭЭЛЛИЙГ МЭДЭЖ ӨӨРЧЛӨХИЙГ ХИЧЭЭХЭЭ ЭНХЛЭНД АМЛАЛАА.


АЙДАС тай
ХАЙР гэж
БАЙДАГГҮЙ


НАМУУНАА БОЛ ӨНДӨР ГООЛИГ БИЕТЭЙ, БАГА НАСНААСАА ЗАГВАРЫН ААМЖААНА ЯВСАН ӨӨРТӨӨ ИТГЭЛТЭЙ, УХААЛАГ, ИХ СУРГУУЛЬД ИНЖЕНЕРЭЭР СУРАЛЦДАГ 3-Р КУРСЫН ОЮУТАН.
ТЭРЭЭР САЙХАН ТЭЛМЭН ГЭХ ЗАЛУУТАЙ УЕРХЭЖ ЭХЭЛЖЭЭ.


НАМУУНДАА МЭРГЭЖИЛДЭЭ ДУРТАЙ БӨГӨӨД УР ЧАДВАРАА АХИУЛАХ ГЭЖ "ЗАЛУУ ИНЖЕНЕРҮҮДИЙН КЛУБ"-Т ЯВДАГ. УУЛЗАЛТ БҮРИЙНХЭЭ ДАРАА ТЭР ТЭЛМЭНТЭЙ УУЛЗАЖ ЦАГИЙГ ХАМТ ӨНГӨРӨӨДӨГ БАЙВ.
ЗА БАЯРТАЙ! МАРГААШ УУЛЗАЦГААЯ!
БАЯРТАЙ!


КЛУБЫН УУЛЗАЛТЫН ДАРАА
ЧИ БАЙНГА ТҮРҮҮЛЭЭД ГАНЦААРАА ЯВАХ ЮМАА. ӨНӨӨДӨР ХАМТДАА ГАРЦГААЯ ГЭЖ БОДОЦГООЖ БАЙНА.
ГАНЦ УДАА БИД НАРТАЙ ХАМТ ЖААХАН СУУЧИХААЧ? НАМУУНАА?
ЗА ТЭГЬЕ, НЭЭРЭЭ ТА ХЭДТЭЙ ЕРӨӨСӨӨ ГАРЧ ҮЗЭЭГҮЙ ЮМ БАЙНА.
ХӨГЖИЛТЭЙ БАЙЦГААНА АА!
БАЙНА УУ? ТЭЛМЭН, БИ КЛУБЫНХАНТАЙГАА ХАМТ ГАРАХААР БОЛЛОО ШҮҮ.
ДАРАА УУЛЗАЯ.


ДИН ДИН
НАМУУНДАА, ДАРС УУХ УУ?
ҮГҮЙ ЭЭ, БАЯРЛАЛАА.
НАЙЗ НЬ СОГТУУРУУЛАХ УНДААГҮЙ Ч САЙХАН ХӨГЖИЛДӨЖ ЧАДНА ШҮҮ!
ДҮНЦ ДҮНЦ
БИМ БИМ


ТАНЫ ЗАЛГАСАН ХЭРЭГЛЭГЧ ХАРИУ ӨГӨХГҮЙ БАЙНА . . .
ОДОО ГЭРТЭЭ ИРСЭН БАЙМААР ЮМ. СОНИН ЮМ ААА..
САНАА ЗОВООД БАЙНА, ГЭРТ НЬ ОЧИЖ ҮЗЭЭГ ЮМУУ.
ХААГУУР БАЙГАА ЮМ БОЛ ДОО ..
ЭНЭ ҮЕД ТЭЛМЭН НАМУУНАА РУУ БАЙН БАЙН ЗАЛГАСААР УТАС НЬ ХОЛБОГДОХГҮЙ БОЛОХООР САНАА ЗОВОН ГЭРТ НЬ ОЧИХООР ХУВЦАСЛАЖ БАЙВ.


ӨНӨӨДӨР ЁСТОЙ ХӨГЖИЛТЭЙ БАЙЛАА ШҮҮ!
ХАРИН ТИЙМЭЭ!
ЁСТОЙ ГОЕ БАЙЛАА!
ТАКСИ!
TAXI
ХЭДҮҮЛЭЭ ЭХЛЭЭС НЬ НАМУУНААГ БУУЛГАХ УУ?
ХАМГИЙН ОЙРХОН ГЭРТЭЙ НЬ.
ТЭГЬЕ! ААРАА НЬ НАМАЙГ!
САЙХАН АМРААРАЙ!
ЦАГИЙГ ГАЙХАЛТАЙ ӨНГӨРӨӨСӨН ШҮҮ!
САЙХАН АМРААРАЙ!


МАРГААШИЙН НАР ЛУУ ХАМТ АЯЛАХ УУ~
ЯМАР ИХ БУЖИГЛАВЭЭ, МММ
ОРЦ II
..
ТЭЛМЭЭН?
ЧИ ЭНД ЮУ~


ЗАЛГААД БАЙХАД УТСАА АВАХАА ЯАДАГ ЮМ?
ЯАСАН УДААН ГАРДАГ ЮМ ЧИ!
АЙН?
ТАС


ТЭЛМЭН НАМУУНДАА РУУ УУЧЛАЛТ ГУЙЖ ЗАЛГАСАН Ч НАМУУНДАА ХҮЛЭЭЖ АВАХЫГ ХҮССЭНГҮЙ.. УЧИР НЬ ТЭЛМЭН ӨӨРИЙГ НЬ ОЙЛГОХЫГ ХҮСЭЛГҮЙ, ГАР ХҮРЭХЭЭ УРЬТАЛ БОЛГОН АЛГАДСАН НЬ БАЙЖ БОЛШГҮЙ ҮЙЛДЭЛ ГЭЖ НАМУУНДАА БОДОЖ БАЙВ.
НАМУУНДАА ДАРАА ДАРААГИЙН АЮУЛААС Ч АЙЖ БАЙЛАА


ТЭЛМЭН Ч ӨӨРИЙН ГАРГАСАН БОЛЧИМГҮЙ ҮЙЛДЭЛДЭЭ ГЭМШИН НАМУУНААГААС УУЧЛАЛТ ГУЙХЫН ТУЛД БҮХИЙ Л АРГЫГ ХЭРЭГЛЭЖ БАЙЛАА.
SORRY
SORRY
ХАЙРЫГАА УУЧЛААРАЙ, МИНИЙ БУРУУ! БИ АЛДААГАА ЗАСАХЫН
НАМУУНАА НАДАД БОЛОМЖ ОЛГООЧ ДЭЭ!
I LOVE YOU SO MUCH!
БИ МАШ ИХ ГЭМШИЖ БАЙНАА, НАМАЙГ УУЧЛААЧ!
НАМУУНАА, ХАРИУ ӨГӨӨЧ ГУЙЖ БАЙНА..


НАМУУНДАА ТЭЛМЭНГИЙН ГАРГАЖ БУЙ ЦАЭВХИ ЗҮТГЭЛИЙГ ҮНЭЛЖ НЭГ УДАА УУЛЗАХААР БОЛОВ.
НАМУУНДАА, НАМАЙГ УУЧЛААЧ!
КЛУБЫХАНТАЙГАА ГАРАХ БОЛСОНОО ХЭЛСЭЭР БАЙХАД ЧИНИЙ ГАРГАСАН ТҮРЭМГИЙ ҮЙЛДЭЛ НАДАД АЙМШИГТАЙ САНАГДСАН.
БИ НАЙЗУУДТАЙГАА ГАРЧ ОРЖ БОЛНО.
ХЭН Ч НАМАЙГ ЗАХИРЧ ХЯНАХ ЭРХГҮЙ. БАС НЭГ УДАА ГАР ХҮРСЭН БОЛ ДАХИН ГАР ХҮРЭХИЙГ ҮГҮЙСГЭХГҮЙ. БИ АЙЖ БАЙНА.


ТИЙМ ЭЭ, ЧИНИЙ ХЭЛСЭН БҮХЭН ҮНЭН. ГЭХДЭЭ ОДОО БИ ДАХИЖ ХЭЗЭЭ Ч ИЙМ ҮЙЛДЭЛ ХИЙХГҮЙ.
БИ АМЛАЖ БАЙНА.
НАМАЙГ УУЧЛААЧ ДЭЭ!
ГУЙЖ БАЙНА!
ЭНЭ УДААД ИТГЭЭД УУЧИЛЛАА ....
ХАЙРТАЙ ШҮҮ, НАМУУНАА. МАШ ИХ БАЯРЛАЛАА!
БАЯРЛАЛАА!


ХЭСЭГ ХУГАЦААНД ТЭР ХОЁРЫН ХАРИЛЦАА ХЭВИЙН ҮРГЭЛЖИЛЖ БАЙВ. УДАЛГҮЙ НАМУУНААГИЙН ХҮСЭН ХҮЛЭЭДЭГ ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ТОВ ГАРЧЭЭ.
?
ХӨӨХ!
ЭНЭ ТЭМЦЭЭН МИНИЙ ХУВЬД ЯМАР ЧУХАЛ ГЭЭЧ!
САЙН ОРОЛЦОЖ ЧАДАХ ЮМ БОЛ МЭРГЭЖЛЭЭРЭЭ ГАДААДЫН ИХ СУРГУУЛЬД ТЭТГЭЛЭГТЭЙ СУРАЛЦАХ БОЛОМЖТОЙ БОЛОХ НЬ БАЙНА!
ХИЧЭЭХ ХЭРЭГТЭЙ!


ХИЧЭЭХ ХЭРЭГТЭЙ!
БИ ЗААВАЛ ТҮРҮҮЛНЭ!
ӨНӨӨДӨР ОРОЙТОХ НЬ БАЙНА ШҮҮ, ТЭЛМЭН. УУЛЗАЖ АМЖИХГҮЙ НЬ ЭЭ..
АХИДА Л УУ? МАРГААШ ЗАВТАЙ ЮУ ТЭГВЭЛ?
ЭНЭ
?
x = 2a + 6
ИЙНХҮҮ НАМУУНАА ӨӨРТ БУЙ БҮХИЙ Л НӨӨЦ БОЛОМЖООРОО ҮГ ТЭМЦЭЭНД БЭЛДЭЖ ЭХЭЛЛЭЭ. ЭНЭ ТУХАЙГАА ТЭЛМЭНД ХЭЛСЭН БӨГӨӨД ТҮҮНТЭЙ АЛЬ БОЛОХ БАЙНГА УУЛЗАХЫГ ХИЧЭЭНЭ.


АРАЙ ДУУСААГҮЙ Л БАЙНА. БОЛООГҮЙ ЮМ ШИГ БАЙНА ДАА.
БИ ЧАМАЙГ ХҮЛЭЭЖ БАЙГААД АВАХ УУ?
ЯАХ ЮМ БЭ, БИ ӨНӨӨДӨР ӨӨРӨӨ ХАРИНА АА.
АХИАД Л УУ...
АЛИВ, ГЭРТ ЧИНЬ ХҮРГЭЭД ӨГЬЕ.
ТЭЛМЭН?
БИ ХАРИХ БОЛООГҮЙ БАЙНА АА. ТЭМЦЭЭН УДАХГҮЙ БОЛЛОО, ХИЙХ ЗҮЙЛ Ч ИХ БАЙНА.
БАЙНГА ИНГЭЖ ОРОЙТОЖ БОЛОХГҮЙ ШҮҮ ДЭЭ.
ИНЖЕНЕР МЭРГЭЖЛЭЭР СУРАЛЦАГСДЫН ИХЭНХ НЬ ЭРЭГТЭЙЧҮҮД БӨГӨӨД НАМУУНААГ ТЭМЦЭЭНД ОРОХООР БЭЛТГЭЖ БАЙГААГ МЭДСЭЭР БАЙВЧ СУРГУУЛЬ ДЭЭРЭЭ ЭРЧҮҮДТЭЙ БАЙНГА ОРОЙТОХ НЬ ТЭЛМЭНГИЙН УУРЫГ ХҮРГЭЖ БАЙВ.


ЧИ ЕР НЬ ХИЧЭЭЛЭЭ ХИЙГЭЭД БАЙГАА ЮМ УУ,
ЭРЧҮҮДТЭЙ ИНЭЭЛДЭЭД, АЛЦГАНААД БАЙГАА ЮМ УУ? АЙН?
ТҮРҮҮН АНГИЙН ЧИНЬ ХААЛГААР ХАРАХАД ТИЙМ Л БАЙСАН!
ОДОО ЮУ Ч ГЭХЭВ ДЭЭ!
БИ ЮУ ХИЙЖ БАЙГААГАА ЧАМД ЗӨНДӨӨ ХЭЛСЭН!
ЧИ МУУ-
ТАС


БИ ЕР НЬ ЧИНИЙ ӨМЧ ҮҮ? БИ ЧАМАЙГ НЭГ УДАА УУЧИЛСАН.
ГЭТЭЛ ЧИ НАМАЙГ ҮГ ХЭЛЭЭР ДОРОМЖИЛЖ, ДАХИН ГАР ХҮРЛЭЭ.
БИ ЧАМД ИТГЭЭД УУЧИЛЖ БАЙХАД ЧИ НАМАЙГ ОЙЛГОСОНГҮЙ, ХҮНДЭЛСЭНГҮЙ БАС ХАЙРЛАСАНГҮЙ. ДАХИЖ НАДТАЙ ХАРЬЦАХ ХЭРЭГГҮЙ, УУЧЛАЛТ ГУЙСНЫ Ч ХЭРЭГГҮЙ. ИНГЭЭД БИД ХОЁРЫН ХАРИЛЦАА ДУУСЛАА!


БИ-
БИ ЮУ ХИЙЧИХЭВ ЭЭ
...
БИ ЮУ ХИЙХ НЬ ЭНЭ ВЭ?
...


ХОЖИМДООГҮЙ
Ухаарал


9-Р АНГИЙН НЭГЭН БҮЛЭГТ БОЛДОО ГЭДЭГ САХИЛГАГҮЙ ХҮҮ БАЙВ. АНГИЙНХ НЬ ОХИД ТҮҮНИЙ ХАЖУУГААР ӨНГӨРӨХӨӨС Ч АЙН ХОЛУУР ТОЙРОХ, АЛЬ ЭСВЭЛ ЯВАХЫГ НЬ ХҮЛЭЭН ХОЛООС ХАРЖ ЗОГСОНО.
ЭЭ, БОЛДОО БАЙНА ...
ХАРИН ЯАХ УУ?
?
ЯДНА АА, ХАРЧИХЛАА !...


ЯАСАН БОГИНО ХОРМОЙ ВЭ, АЙН?
ХҮҮЕ!!.....
ХӨӨЕ!!
ХӨӨХ, ТОМ БОЛЧИХСОН БАЙНА ШТ!
МӨӨМ БАРЬЯ~
САЙХАН ХҮҮХЭН БОЛЖЭЭ ЧИ~~~
...
БОЛДОО ОХИДЫН ХОРМОЙГ СӨХӨЖ, ЦЭЭЖИНД НЬ ХҮРЧ, НАСАНДАА ТОХИРОМГҮЙ ҮГСИЙГ ИЧИХ Ч ГҮЙ ЧУЛУУДНА.


БОЛДОО УГ НЬ АЛЬ НЭГДҮГЭЭР АНГИАСАА ХАМТ СУРСАН, НИЙТЭЧ, ТУСАРХАГ ХҮҮ ГЭДГИЙГ АНГИЙНХАН НЬ МЭДНЭ. ГЭТЭЛ ХЭЗЭЭНЭЭС Ч ЮМ ГЭНЭТ Л ИЙМ СОНИН ЗАН, ҮЙЛДЭЛ ГАРГАДАГ БОЛЖ.
МӨӨМ БАРЬЯ~
МММ, МӨӨМ БАРЬЯ~
ДАХИАД ХҮРЭЭД ҮЗЭЭРЭЙ ЧИ, АЙН!
ЧАМАЙГ ДАА, МУУ БОЛДОО!
ОХИД Ч ТОГЛООМ ШОГЛООМООР ХҮЛЭЭН АВЧ, ХӨӨЦӨЛДӨЖ БАРЬЖ АВАН ДЭМИЙ Л НИЙЛЖ ЦОХИНО. ГЭСЭН ХЭДИЙ Ч ТҮҮНИЙ ҮЙЛДЭЛ УЛАМ ЛАВШИРСААР Л.



БОЛДОО ЯМАР НЭГЭН ХЭРЭГ ТАРЬСАН ЮМУУ, ОХИДОО?
ААН, ҮГҮЙ ЭЭ БАГШАА.
БИД НАР ТОГЛООД Л...
ГЭХДЭЭ ТҮҮНИЙ ЭНЭ ҮЙЛДЛИЙГ АНГИЙНХ НЬ ОХИД БАГШДАА ХЭЛЖ ҮЛ ЗҮРХЛЭНЭ. УЧИР НЬ БОЛДОО ЭНГИЙН ҮЕДЭЭ ИХ ТУСАРХАГ.


ГЭТЭХ
ТАС
ӨГЗӨГ ЧИНЬ УЛАМ ТОМ БОЛЧИХСОН БАЙНА УУ ДАА, НАМУУНДАА МИНЬ!
ИИИИЙ


?
НАМУУНАА, ЗҮГЭЭР ҮҮ? АЛИВ, МАНАЙ ӨРӨӨ РҮҮ ЯВАХ УУ?
БОЛДОО БАЙНГА ИНГЭДЭГ ҮҮ?
Б-БОЛДОО БҮХ Л ОХИДЫГ ТЭГДЭГ ..
НАМУУНАА, ТАЙВШИР. НААДАА ЮУ БОЛСОН ТУХАЙ ЯРИАД ӨГӨӨЧ?


ЗА ОХИДОО БИ ЭНЭ СУРГУУЛИЙН НИЙГМИЙН АЖИЛТАН БАЙНА.
ТА НАРААС АСУУХ ЗҮЙЛ БАЙНА. БОЛДОО ТА НАРЫГ ДАРАМТАЛДАГ УУ?
ХӨХ, БӨГСӨНД ЗӨВШӨӨРӨЛГҮЙ ХҮРДЭГ.
ЯНЗ БҮРИЙН МУУХАЙ ЮМ ХЭЛДЭГ!
ХАРИН ТИЙМ, ТЭГЭЭД ЗУГТААД Ч НЭМЭРГҮЙ ...
БОЛДООГООС АЙГААД БАЙХ ЮМАА ...


ЮУ?
БИ ЯАГАА Ч ҮГҮЙ ШҮҮ ДЭЭ-
БОЛДОО, ЧИНИЙ ГАРГАДАГ ЭНЭХҮҮ ҮЙЛДЭЛ ЖИРИЙН ЗҮЙЛ БИШ.
ХҮНД ШАЛИГ ЗАВХАЙ ҮГ ХЭЛЭХ,
ХҮНИЙ ЭМЗЭГ ГАЗАРТ ДУРААРАА ХҮРЭХ НЬ БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН НЭГ ХЭЛБЭР.


ҮГҮЙ ЭЭ, БАГШАА.
БИ ЗҮГЭЭР Л ТОГЛОЖ ТЭГДЭГ ШТЭЭ.
ЮУ ГЭЖ БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ БАЙДАГ ЮМ. ТА АРАЙ ХЭТЭРЧ БАЙНА ДАА!
ЧИ ТЭГВЭЛ ЭНЭ АППЛИКЕЙШНД БАЙГАА МЭДЭЭЛЛИЙГ УНШААД МАРГААШ НАДТАЙ ИРЖ УУЛЗААРАЙ.
2:35PM
Хүчирхэг охид
Хүчирхэг улс



ЗУРАГТААР БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭГЧ ГЭЖ ЯРИАД БАЙДАГ АЙМАР ХҮМҮҮСИЙГ НАДТАЙ АДИТГАААД...
БАГШ ОДОО АРАЙ Ч ДЭЭ, ТЭ?
ЭНЭ ЧИНЬ ТОГЛООМ Л ТӨДИЙ ШҮҮ ДЭЭ!
ГЭХДЭЭ, БАГШИЙН ХЭЛСЭН ҮНЭН БОЛ, ЯАНА АА?
ЕРДӨӨ Л, ТОГЛООМ ...


ХҮЧИРХЭГ ОХИД, ХҮЧИРХЭГ УЛС ГЭНЭЭ...
ХӨӨХ...
ХИЧЭЭЛ ТАРМАГЦ БОЛДОО ГЭРТЭЭ ШУУД ОЧИН "ХҮЧИРХЭГ ОХИД, ХҮЧИРХЭГ УЛС" АППЛИКЕЙШНИЙГ УТСАНДАА СУУЛГАН ДОТОРХ МЭДЭЭЛЛИЙГ УНШИЖ ЭХЛЭВ.


ХӨӨХ, ЯМАР ИХ МЭДЭЭЛЭЛТЭЙ АППЛИКЕЙШН ВЭ?
ХҮЧИРХЭГ ОХИД ХҮЧИРХЭГ УЛС
1
2
3
4
ХИЧЭЭЛ ДЭЭР ЗААДАГГҮЙ ИХ ЮМ МЭДЭЖ АВЛАА ШҮҮ!


ГЭТЭЛ БОЛДОО БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ТӨРӨЛ ДОТОР ӨӨРИЙНХ НЬ ГАРГАДАГ ЗАН, ҮЙЛ ХӨДЛӨЛ ОРСОН БАЙХЫГ ХАРААД ӨӨРӨӨСӨӨ МАШ ИХ ИЧИВ.
БУРХАН МИНЬ- БИ БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭГЧ ГЭЖ ҮҮ? АРАЙ ҮГҮЙ БАЙЛГҮЙ ДЭЭ!
ГЭХДЭЭ...
МИНИЙ ГАРГАДАГ ЗАН МӨН БАЙНА ШҮҮ...
ОХИДООД ЯМАР ХЭЦҮҮ БАЙСАН БОЛ ...
БИ ЯМАР ТЭНЭГ ЮМ БЭЭ ...
БОЛДОО ШӨНӨЖИНГӨӨ ОРОН ДОТРОО ХӨРВӨӨН, ЗАН ДААШАА БОДОЖ ХЭВТСЭЭР ӨГЛӨӨГ УГТАВ.


ТҮГ
ТҮГ
БАГШАА, ОРЖ БОЛОХ УУ?
БАГШАА, БИ ТАНЫ ЗААЖ ӨГСӨН АППЛИКЭЙШН РУУ ОРЖ МЭДЭЭЛЭЛ УНШЛАА.
ТЭГЭЭД .... ТАНЫ ЗӨВ БАЙСАН БАЙНА АА ...
БИ ОДОО ЯАХ ВЭ? АНГИЙНХАА ОХИДТОЙ ЯАЖ ХАРИЛЦАХ ЁСТОЙ ВЭ?
ӨӨРӨӨСӨӨ ИЧИЖ БАЙНА. ТА НАДАД ТУСЛААЧ?


ЗА ТЭГЬЕ. БИ ЧАМД ТУСЛАЯ.
ХАРИН ЧАМД ЯМАР ТУСЛАМЖ ХЭРЭГТЭЙ БАЙНА? ЧИ ӨӨРИЙНХӨӨ БУРУУГ УХААРСАН ЧИНЬ САЙН БАЙНА.
ДАХИЖ ИЙМ ҮЙЛДЭЛ ГАРГАЛГҮЙ, ИЙМЭРХҮҮ ҮЙЛДЭЛ ГАРГАЖ БАЙГАА ХҮМҮҮСИЙГ ТАСЛАН ЗОГСООЖ БАЙГААРАЙ.
БАС АНГИЙНХАА ОХИДООС УУЧЛАЛТ ГУЙНА ГЭДЭГ ЧИНЬ ЗӨВ БАЙНА ШҮҮ.
УХААНТАЙ ХҮҮ БАЙНА ШҮҮ, БОЛДОО.


НИЙГМИЙН АЖИЛТАН, БОЛДОО ХОЁР ТАЙВАН СУУЖ АНГИЙНХАНААСАА ХЭРХЭН УУЧЛАЛ ГУЙХ ТУХАЙ ЯРИЛЦЖЭЭ.
БИ ЕРӨӨСӨӨ ОГТ МЭДСЭНГҮЙ, ЮУ ХИЙЖ БАЙГААГАА.
ТОГЛООМ Л ГЭЖ БОДОЖ БАЙСАН.
ЧИ ИХ ЗӨВ ЗҮЙЛ ОЙЛГОСОН БАЙНА ШҮҮ.
ХОЕУЛАА ЯРИЛЦААД, ЯАЖ УУЧЛАЛТ ГУЙХЫГ ЧИНЬ ШИЙДЭХ ҮҮ?
НИЙГМИЙН АЖИЛТАН ТҮҮНЭЭС АСУУЖ БОЛД БОДОЖ БАЙСАН БҮХИЙ Л ЗҮЙЛЭЭ ХЭЛЖЭЭ.


БОЛДОО?
?
ОХИДОО, НАМАЙГ УУЧЛААРАЙ.
БИ ТА НАРТ ГАРГАДАГ БАЙСАН МУУХАЙ БҮДҮҮЛЭГ ЗАНДАА ГЭМШИЖ БАЙНА.
ТА НАРТ ИЙМ ХЭЦҮҮ САНАГДДАГ ГЭЖ ЕРӨӨСӨӨ МЭДСЭНГҮЙ. БИ ДАХИЖ ТА НАРЫГ ГОМДООХГҮЙ ЭЭ!
БИ ЗАСРААД САЙН ХҮН БОЛОХ ГЭЖ МАШ ИХ ХИЧЭЭНЭ!


ИТГЭЛИЙН ӨЧ
ХЭЗЭЭ Ч
БӨХӨХГҮЙ


АНХИЛУУН, ТЭНҮҮН ХОЁРЫН ҮЕРХЭЛ АРВАН ЖИЛИЙН НЭГ ШИРЭЭНЭЭС ЭХЭЛСЭН.
ТЭД ХҮССЭН СУРГУУЛЬДАА АМЖИЛТТАЙ ЭЛСЭН СУРАЛЦАЖ БУЙ ОЮУТНУУД.


АНХИЛУУНЫ ЭЦЭГ ЭХ ӨӨРСДИЙН ХҮЧЭЭР БИЗНЕС ЭРХЭЛЖ, ОХИНОО ЮУГААР Ч ДУТААЛГҮЙ ӨСГӨСӨН Ч ТЭР БАЯН АЙЛЫН ЭРХ ХҮҮХЭД БОЛЖ ӨСӨӨГҮЙ ЮМ.
ТЭНҮҮН, АНХИЛУУН ХОЁР ХЭНИЙ Ч ТУСЛАЛЦААГҮЙ ӨӨРСДИЙН ХҮЧ ХӨДӨЛМӨРӨӨР АМЬДРАЛАА БОСГОХ МӨРӨӨДӨЛТЭЙ.


PREGNA
ХОЁР ЗУРААС ...
ХАЙРАА, ХОЁУЛАА ХҮҮХЭДТЭЙ БОЛОХ НЬ БАЙНА ШҮҮ ДЭЭ!
ЯМАР ГАЙХАЛТАЙ МЭДЭЭ ВЭ! ХАЙРТАЙ ШҮҮ, ТА ХОЁРТОО!
ИХ СУРГУУЛЬД ЭЛСЭЭД УДААГҮЙ БАЙХДАА АНХИЛУУН ЖИРЭМСЭН БОЛЖЭЭ. ХОСУУД БАЯРТАЙ БАЙСАН Ч, ЭНЭХҮҮ МЭДЭЭГ ЭЦЭГ ЭХДЭЭ ХЭЛЭХЭЭС ЭМЭЭЖ БАЙЛАА.
ХҮҮХЭД ГЭДЭГ АЗ ЖАРГАЛ ШҮҮ!


ЖИРЭМСЭН ГЭНЭ ЭЭ? ...
ЭЭЖЭЭ, БИ ТАНЫГ НАДААС БОЛЖ ГАДААДАД СУРЧ ЧАДААГҮЙ, ТҮҮНДЭЭ ХАРАМСДАГИЙГ МЭДНЭ ЭЭ.
ГЭХДЭЭ БИ ТЭНҮҮНТЭЙ ХАМТ ХҮҮХДИЙНХЭЭ ХАЖУУГААР СУРГУУЛИА ТӨГСӨЖ ЧАДНА АА.
ТА ЧАДСАН ЮМ ЧИНЬ ОХИН НЬ БАС ХИЧЭЭНЭ ЭЭ!
БАЯР ХҮРГЭЕ!
ӨВӨӨ БОЛОХ НЬ БАЙНА ШҮҮ ДЭЭ!
АНХИЛУУН ААВ ЭЭЖДЭЭ ХЭЛЭХЭД ЭЦЭГ ЭХ НЬ ТИЙМ Ч ТААТАЙ ХҮЛЭЭН АВААГҮЙ Ч, ТЭНҮҮНИЙГ САЙН ХҮҮХЭД ГЭЖ ИТГЭН ОХИНОО ДААТГАН ӨГӨВ.


АЙЛ ГЭРИЙН АМЬДРАЛЫГ
ЭР ХҮН АВЧ ЯВАХ ЁСТОЙ ГЭСЭН
УЛАМЖЛАЛТ СЭТГЭЛГЭЭТЭЙ
ТЭНҮҮН АНХИЛУУНЫГ ГЭРТЭЭ
АМЬДРУУЛАХ ХҮСЭЛТЭЙ
БАЙСАН ТУЛ ТЭД ТЭНҮҮНИЙНД
ХАМТДАА АМЬДРАХААР НҮҮЖ ОЧИВ.


АНХИЛУУНД ГЭР ХОРООЛОЛД АМЬДРАХ ХЭЦҮҮ БАЙСАН Ч УДАЛГҮЙ ДАСАХ БАЙЛГҮЙ ДЭЭ ГЭЖ БОДСООР БАЙВ.
АНХИЛУУН?
ХӨӨЕ, ЗҮГЭЭР ҮҮ?
ЭМЧ ДУУДААРАЙ!
АНХИЛУУН ТӨРӨХ ХҮРТЭЛ ХИЧЭЭЛДЭЭ ЯВНА ГЭЖ ГҮРИЙСЭН Ч БИЕ НЬ МУУДАЖ ЧӨЛӨӨ АВАХААС ӨӨР АРГАГҮЙ БОЛОВ.
ЦАГ ХУГАЦАА ӨНГӨРЧ, ТЭД ХӨӨРХӨН ХҮҮТЭЙ БОЛЛОО.


НАДТАЙ ТӨСТЭЙ Ч ЮМУУ?
ААВТАЙГАА АДИЛХААН!
ЯАСАН МУУХАЙ ХҮҮХЭД ВЭ!
АНХИЛУУНАА, ААВ ЭЭЖИЙНХ НЬ ЯРЬЖ БАЙСАН АЖИЛ БҮТЭЖ, БИД УДАХГҮЙ АМЕРИК ЯВАХААР БОЛЛОО ...
ӨНӨӨ МАРГААШГҮЙ ЯВАХ БЭЛТГЭЛЭЭ ХИЙХ НЬ ЭЭ.
ЗАЛУУ ХОСУУДАД МӨНГӨ ХЭРЭГТЭЙ Л БАЙЛГҮЙ, САНАА ЗОВОЛТГҮЙ ХЭЛЭЭД АВААРАЙ!
БИД ӨӨРСДӨӨ БОЛГОНО ОО, ЭЦЭГ ЭХЭЭСЭЭ АВААД ХЭРЭГГҮЙ.
ӨӨ ЗҮГЭЭР ЭЭ, БИД ХОЁР УЧРАА ОЛЧИХНО. САНАА БҮҮ ЗОВООРОЙ.
ТА ХОЁР ӨӨРСДИЙГӨӨ Л БОД.


ҮНЭНДЭЭ ЭНД ИРСЭНЭЭС ХОЙШ ШИНЭ ХУВЦАС, БУДАГ Ч АВСАНГҮЙ.
УГ НЬ ХАМАГ ЮМ ДУУСААД УДАЖ БАЙНА ДАА ...
SUPER SALE 30%
...
SUPER SALE 30%
...
ЗА ЯАХАВ, БОЛНО ДОО. УДАХГҮЙ БИ Ч СУРГУУЛЬДАА БУЦААД ОРНО. ТӨГСӨӨД АЖИЛД ОРЖ САЙХАН АМЬДРАХ ЦАГ ИРЖ Л ТААРНА.


УДАЛГҮЙ ХҮҮ НЬ ОЙ ГАРАНТАЙ БОЛЖ АНХИЛУУН ХИЧЭЭЛДЭЭ ЭРГЭЖ ОРОХ ГЭТЭЛ...
ЭЭЖЭЭ!
ХОЕР ЗУРААС ...
БИ ЖИРЭМСЭН БОЛЧИХСОН БАЙНА...
НЭГ ХОЕРЫН ЯЛГАА ЮУ БАЙХАВ ДЭЭ! БОЛНО ОО, ХОЕУЛАА!
...


АНХИЛУУНАА!
ӨНӨӨДӨР ГАРАХ УУ?
САЙХАН УУЛЗААД КАРАОКЕ ОРОХ УУ?
ЧАМАЙГ ХАРААГҮЙ УДАЖ!
ГАРЧ ОРОХОД МӨНГӨ ХЭРЭГТЭЙ, ЯДАЖ Л ГАЙГҮЙ ХУВЦАС ӨМСӨХГҮЙ БОЛ НАЙЗУУД МУУ ХЭЛНЭ.
ТЭНҮҮН МААНЬ АМЬДРАЛАА АВЧ ЯВАХ ГЭЖ ХИЧЭЭЖ БАЙХАД НЭРМЭЭС БОЛООД ЯАХАВ.
ӨӨ, САЙН УУ ЭЭЖЭЭ? ХҮҮ ТОМ БОЛЖ БАЙНА АА.
МИНИЙ БИЕ ДАЖГҮЙ ЭЭ, ЗҮГЭЭР. БҮХ ЮМ САЙХАН БАЙНА АА, ЭЭЖЭЭ.
БИД БОЛЖ БАЙНАА. ЗҮГЭЭР ЭЭ.
НАЙЗ НӨХӨД НЬ УУЛЗАХ ГЭХЭЭР АНХИЛУУН МӨНГӨГҮЙ ТУЛ ТАТГАЛЗАЖ, ШАЛТАГ ХЭЛСЭЭР ОДОО УТСААР ЯРИХ Ч НАЙЗГҮЙ ҮЛДЭЖ. ХАРИН ЭЭЖ НЬ БАЙНГА ЗАЛГАЖ, ОХИНООСОО АМЬДРАЛЫГ НЬ АСУУНА.


ИЙНХҮҮ ЦАГ ХУГАЦАА ӨНГӨРЧ ТЭНҮҮН СУРГУУЛИА ТӨГСӨН АЖИЛД ОРЖ ОДОО Л НЭГ САЙХАН АМЬДРАХ БОЛОМЖ БҮРДЛЭЭ ГЭЖ БАЙТАЛ БАЙДАЛ УЛАМ ДОРДОЖ БАЙВ.
АНХИЛУУН ДӨРВӨН ЖИЛ ГЭРТЭЭ СУУН ХҮҮХДҮҮДЭЭ АСАРСАН ТУЛ МЭДЛЭГ БОЛОВСРОЛГҮЙГЭЭСЭЭ БОЛЖ АЖИЛД ГОЛОГДОЖ БАЙЛАА.


ТЭНҮҮН Ч АЖИЛ ИХТЭЙ БАЙНА ГЭЖ ОРОЙН ЦАГААР АРХИ ҮНЭРТҮҮЛЭН ОРЖ ИРДЭГ БОЛЖ, АВЧИРСАН МӨНГӨ НЬ ОЮУТАН БАЙХДАА ОЛЖ БАЙСАН МӨНГӨНӨӨС ХЭТЭРСЭНГҮЙ.


МИНИЙ ӨГСӨН МӨНГИЙГ ИЙМ ХУРДАН ДУУСГАЧИХСАН ЮМУУ?
ТЭР ЧИНЬ ХҮНС, ЖИВХЭНД Л ЯВЧИХСАН ШҮҮ ДЭЭ.
ГЭРИЙН ЗҮЙЛСЭЭС ГАДНА БИ БАС ЮМ АВМААР БАЙНА ШҮҮ ДЭЭ,
ХАЙРАА ...
ЧИ ЁСТОЙ ҮРЭЛГЭН ЮМАА. ӨГӨӨД БАЙХАД Л ХАНАХГҮЙ ЮМ?
ГЭРЭЭС ГАРДАГГҮЙ ЧАМД ЕР НЬ ЯМАР ХЭРЭГ БОЛДОГ ЮМ?
ГЭХДЭЭ ...
ХАА Ч ХҮРЭХГҮЙ БАЙНА ШҮҮ ДЭЭ ...
ГЭР БҮЛИЙН САНХҮҮГЭЭ НӨХӨР НЬ БАРИХ БОЛЖ ХООЛ УНДНЫ МӨНГӨНӨӨС ИЛҮҮГ АНХИЛУУНД ӨГӨХГҮЙ. АНХИЛУУН ТЭНҮҮНИЙГ МӨНГӨ ХУРААЖ БАЙГАА ГЭЖ БОДОЖ БАЙСАН Ч ТИЙМ ЮМ БАЙСАНГҮЙ.


НЭГ ӨДӨР АНХИЛУУНЫ ГЭРИЙНХЭН НЬ МОНГОЛД БУЦАЖ ИРЭВ.
ОХИН МИНЬ САЙН СУУЖ БАЙВ УУ?
ЗА МИНИЙ ЗЭЭ НАР ХААНА БАЙНА?




АНХИЛУУНЫ АМЬДРАЛ ЭЭЖДЭЭ ЯРЬДАГ
БАЙСНААС ТЭС ӨНДӨӨ БАЙЛАА.
ХОЁР ХҮҮХЭД НЬ БҮТЭН ХУВЦАСГҮЙ,
ОЛИГТОЙ ХООЛ УНДГҮЙ,
ОХИН НЬ АЛЬ ДӨРВӨН ЖИЛИЙН
ӨМНӨ ТӨРӨХДӨӨ АВЧ БАЙСАН
ГЭРИЙН ХАЛААДТАЙ УГТАХ НЬ ТЭР.


ХҮҮЕ, ОХИН МИНЬ! ИНГЭЖ АМЬДАРНА ГЭЖ ЮУ БАЙХАВ ДЭЭ?
ЭНД ИНГЭХ ХЭРЭГ ЮУ БАЙНА? ЧИ ХҮҮХДҮҮДЭЭ АВААД ААВ ЭЭЖ ХОЁР ДЭЭРЭЭ ХҮРЭЭД ИР!
БИ НӨХӨР ХҮҮХДҮҮДДЭЭ ХАЙРТАЙ, ААВАА. ТЭНҮҮН ХИЧЭЭЖ БАЙГАА.
БИДНИЙ АМЬДРАЛД БИТГИЙ ОРОЛЦООЧ, ГУЙЖ БАЙНА.


ГЭХДЭЭ АНХИЛУУНЫ ТОЛГОЙД ГАНЦХАН БОДОЛ БАЙНГА ЭРГЭЛДЭЭСТЭЙ ...
ЭНЭ ХЭВЭЭРЭЭ НӨХРӨӨ ХАРААД БАЙВАЛ БИДНИЙ АМЬДРАЛ УЛАМ ДОРДОНО УУ ГЭХЭЭС ДЭЭРДЭХГҮЙ.
БИ ӨӨРӨӨ ХИЧЭЭЖ ЭХЛЭЭД БОЛОВСРОЛТОЙ БОЛОХ ХЭРЭГТЭЙ.
ХӨӨХ, ЭНЭ ЧИНЬ...
ЭССЭ БИЧЛЭГИЙН УРАЛДААН
ИЙНХҮҮ АНХИЛУУН НӨХӨР ХҮҮХДҮҮДЭЭ УНТСАН ХОЙГУУР ИНТЕРНЭТЭЭР ИХ СУРГУУЛИУДЫН ТАЛААР МЭДЭЭЛЭЛ ХАЙСААР "ЭССЭ БИЧЛЭГИЙН УРАЛДААН" ОЛЖ ХАРЛАА.


АНХИЛУУН Ч ӨЧНӨӨН УДАА НООРОГЛОСООР ЭЦСИЙН ХУВИЛБАРАА ИЛГЭЭЛЭЭ.
АЗ НАМАЙГ ИВЭЭХ БОЛТУГАЙ ....


НЭГЭН ӨДӨР ТҮҮНИЙ УТСАНД ДУУДЛАГА ИРЭВ.
ХОЁР ДОЛОО ХОНОГ ӨНГӨРЧИХЛӨӨ. ТЭМЦЭЭН ЮУ БОЛСОН БОЛ ?...
БАЙНА УУ? ТИЙМ БАЙНА. ДАН ЗА?
ЮУ... ЮУ ГЭНЭ ЭЭ?
БИ ТЭРГҮҮН БАЙР ЭЗЛЭСЭН ГЭЖ ҮҮ?
БАЯР ХҮРГЭЕ! ТАНЫ ЭССЭ
ТЭРГҮҮН БАЙРАНД ШАЛГАРСАН БАЙНА!


ИЙНХҮҮ АНХИЛУУН ТОМ ХҮҮГЭЭ ЦЭЦЭРЛЭГТ, БАГА ХҮҮГЭЭ ЭЭЖДЭЭ ХАРУУЛЖ ХҮССЭН МЭРГЭЖЛЭЭРЭЭ АМЖИЛТТАЙ СУРАЛЦАН ТӨГСЛӨӨ.
АНХИЛУУН СУРГУУЛИА ТӨГСӨН БОЛОМЖИЙН АЖИЛД ОРЖ, САНХҮҮГИЙН ХУВЬД ЭЦЭГ ЭХ, НӨХРӨӨСӨӨ Ч ХАРААТ БУС САЙХАН АМЬДАРЧ БАЙНА.